



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2015.04.23 № 445

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА Б.БОЛОР ТАНАА**

“Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн”-д хийсэн аудитын тайланг хүргүүлэв.

Хүлээн авч танилцана уу.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД




Нийцлийн аудитын А5-бланк



## МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн



**ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН АШИГЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ  
ШААРДЛАГАТАЙ БАЙНА**

Улаанбаатар хот  
2015 он

## Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуйн нэгж
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ГЗТЗТХ	Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хууль
ДБ	Дэлхийн банк
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХЕӨБХ	Дунд хугацааны евро өрийн бичгийн хөтөлбөр
ЗГҮАХ	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
ЗТБХАГ	Зээл тусламжийн бодлого, хамтын ажиллагааны газар
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ОУСБ	Олон улсын санхүүгийн байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХБТХ	Хөгжлийн банкны тухай хууль
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮХААЯ	Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам
ЯОУХАБ	Японы Олон Улсын Хамтын ажиллагааны банк

**АГУУЛГА**

**Аудитыг гүйцэтгэсэн:**

**YAG-ын Гүйцэтгэлийн аудитын газар**

ГАГ-ын дарга: С.Төмөрхүү

Менежер: Д.Баттулга

Ахлах аудитор Ш. Энхтайван  
Б.Болормаа  
Р.Гончигцэрэн

Аудитор Ж.Болормаа

*Аудитын дүн, дүгнэлт,  
зөвлөмжтэй холбоотой  
асуудлаар нэмж тодруулах,  
асууж лавлах, холбогдох саналаа  
өгөхийг хүсвэл 263755, 262451,  
261805 дугаарын утас, 323266  
дугаарын факсаар харилцана уу.*

**ХАЯГ:**

*Үндэсний аудитын газар  
Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-  
3, Засгийн газрын IV байр,  
Улаанбаатар хот 15160*

**МОНГОЛ УЛС**

Товчилсон үгийн жагсаалт..... 1  
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй,  
стандартын талаарх мэдэгдэл ..... 3

**БҮЛЭГ НЭГ. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ..... 4**

- Чингис бондын талаар..... 4
- Самурай бондын талаар..... 5
- Хөгжлийн банкны тухай..... 5
- Төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн талаар 6

**БҮЛЭГ ХОЁР. ЧИНГИС, САМУРАЙ БОНДЫН  
ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР..... 8**

- Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй  
олгосон зээлийн үйл ажиллагааны зардалд  
1 хувийн хүү нэмж төлж байна..... 9
- Хөгжлийн банкны активын удирдлага..... 10

**БҮЛЭГ ГУРАВ. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЛААР..... 13**

- Зээлийн багцын мэдээ..... 13
- Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн  
салбарт олгосон зээл ..... 13
- Уул, уурхай төмрийн хүдрийн төслүүд  
үнийн уналтаас эрсдэл хүлээж болзошгүй  
байна..... 15
- Барилгын салбарт олгосон зээл..... 15
- Хөрөнгийн биржэд олгосон зээл ..... 16
- Бондын хөрөнгөөр хэрэгжүүлж буй ҮХААЯ-  
ны төслүүд зогсонги байдалтай байна..... 16
- Хөгжлийн банкинд гаргах Засгийн газрын  
баталгаа тогтоолд заасан хувь хэмжээг  
хангаж байна..... 18

**Аудитын дүгнэлт..... 20**

**Зөвлөмж..... 21**

**Холбогдох байгууллагын санал..... 23**

**Аудитын бүрэн эрх,  
үндэслэл, зорилт**

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 3 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлэв.

**Хамарсан хүрээ**

Аудитаар Хөгжлийн банкны 2014 оны 12 дүгээр сарын 31-ний өдөр хүртэлх үйл ажиллагаа, түүгээр дамжуулан хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааны хүрээнд шалгалаа.

**Арга зүй, стандартын  
талаарх мэдэгдэл**

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах болон Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитын явцад Халзанбүргэдэй-Солонготын давааны замын ажил, Самурай бондын гаргалтын үйл ажиллагаатай холбоотой зардлын санхүүжилтыг АТГ-аас шалгаж байгаа, автозамын салбарын үйл ажиллагаанд тусгайлсан аудитын багийг томилсон тул эдгээр асуудлыг тайланд тусгаагүй болно.

## БҮЛЭГ НЭГ. ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн Улс орнуудад хөгжлийн банк нь эдийн засгийн хөгжлийн зорилтыг санхүүжүүлэх зорилгоор Засгийн газраас байгуулдаг санхүүгийн институци хэлбэрээр төлөвшиж байна. Хөгжлийн банкны хуульд заасны дагуу Хөгжлийн банк нь Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх зорилго бүхий тусгайлсан чиг үүрэгтэй ашгийн төлөө төрийн өмчит хуулийн этгээд хэлбэрээр байгуулагдсан байна.

### Чингис бонд

УИХ-ын 2012 оны 52 дугаар тогтоолоор эдийн засгийн өсөлтийг хангах, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, экспортыг дэмжих бодлого арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор дунд, урт хугацааны 5.0 тэрбум ам.доллар хүртэлх Засгийн газрын үнэт цаасыг 2012-2014 онуудад үе шаттайгаар олон улсын зах зээлд арилжаалахыг зөвшөөрсөн ба уг хөрөнгийг нийгмийн халамжийн аливаа үйлчилгээ болон улсын төсвийн орлогын дутагдлыг нөхөхөөс бусад эрдэс баялаг, зам, тээвэр, эрчим хүч, харилцаа холбоо, барилга, банк санхүү, аж үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх эдийн засгийн үр ашиг бүхий томоохон төслүүдэд хөрөнгө оруулахад зарцуулахыг Засгийн газарт даалгасан байна.

Энэ хөтөлбөрийн хүрээний эхний үе шатанд 1.5 тэрбум ам.долларын бондын гэрээг 0.5 тэрбум, 1.0 тэрбум ам.долларын 2 хэсэгт хуваан байгуулсан байна:

Хүснэгт 1

Гэрээ	Огноо	Монгол Улсыг төлөөлж	Хөрөнгө оруулагчдыг төлөөлж
Хөтөлбөрийн гэрээ (Program agreement)	2012.11.20	МУЗГ, ЭЗХС	Deutsche bank AG, HSBC limited, Merrill lynch PTE.LTD, J.P.Morgan Securities PLC, TDB Capital LLC
Захиалгын гэрээ (Subscription Agreement)		МУЗГ, ЭЗХС	Deutsche bank AG, HSBC limited, Merrill lynch PTE.LTD, J.P.Morgan Securities PLC, TDB Capital LLC
Агентын гэрээ	2012.11.21	МУЗГ, ЭЗХС	Deutsche bank AG, Hongkong Branch, Deutsche bank Trust Company Americas, Deutsche bank Luxembourg S.A.
Эрх зүйн зөвлөгөө	2012.10.26	МУЗГ, ЭЗХС	Shearman and Sterling, Lehman Lee and Xu Mongol LLC, Law Debenture, Toppan vite limited, Artemis Associates limited,

Дээрх гэрээнүүдэд бондын үндсэн нөхцлийг дараах байдлаар тодорхойлжээ. Зээлийн гэрээний нөхцлүүд:

Хүснэгт 2

Бондын хэмжээ	500.0 сая ам.доллар	1,000.0 сая ам.доллар
Бондын хүү жилийн	4.125 хувь	5.125 хувь
Бондын хугацаа	5 жил	10 жил
Гэрээ байгуулсан огноо	2012.11.28	2012.11.28

Бондыг арилжаалах үйл ажиллагааны зардалд гэрээний дагуу 5.4 сая ам.долларыг суутгуулж, 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монгол банк дахь Засгийн газрын бондын харилцах дансанд 1,494.6 сая ам.долларын орлого орсон байна.

Хууль зүйн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 1/1125 тоот дүгнэлтийн 4 дүгээрт "Гэрээнүүдийг байгуулах, үйлдэх, тэдгээрийн дагуу хүлээсэн үүрэг биелүүлэх, үнэт цаасыг гаргах, санал болгох, худалдах, хүргүүлэх нь Монгол улсын холбогдох

хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчихгүй бөгөөд Монгол улсын Үндсэн хууль, олон улсын гэрээний зүйл заалт, аливаа шүүх, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, түүнчлэн Үнэт цаас гаргагчийн хувьд заавал биелүүлбэл зохих аливаа гэрээ, түүний үүрэгтэй зөрчилдөхгүй “ гэж заасан байна.

### Самурай бонд

Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 417 дугаар тогтоолоор Хөгжлийн банкны ТУЗ-д ЯОУХАБ /JBIC/-ны баталгаатай 30.0 тэрбум иентэй тэнцэх хэмжээний “Самурай” үнэт цаасыг 10 жилийн хугацаатай, гадаад валютаар, хаалттай хэлбэрээр Япон Улсын үнэт цаасны зах зээл дээр гаргахыг зөвшөөрчээ.

Тус бондыг 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр жилийн 1.52 /тогтмол/ хувийн хүүтэйгээр арилжаалж, 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр 24.3 тэрбум иен Хөгжлийн банкны дансанд бүртгэгдсэн.

Самурай бондын гэрээнд 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авагчийг төлөөлж Хөгжлийн банк, Хөрөнгө оруулагч талыг төлөөлж “Дайва секьюритиз” со.Ltd. “Номура секьюритиз” со.Ltd, Шимизаки олон улсын хуулийн байгууллагын төлөөллүүд тус тус гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.

Самурай бонд гаргалттай холбоотой хийгдсэн гэрээ:

Хүснэгт 3

Гэрээ	Огноо	Монгол улсыг төлөөлж	Хөрөнгө оруулагчыг төлөөлж
Зохицуулагчдын гэрээ	2013.12.13	Хөгжлийн банк	Дайва секьюритиз ХХК /Daiwa securities co. ltd/ болон Номура секьюритиз ХХК-ийн /Nomura securities co. ltd/
Худалдах, худалдан авах тухай гэрээ	2013.12.16	Хөгжлийн банк	Дайва секьюритиз ХХК /Daiwa securities co. ltd/ болон Номура секьюритиз ХХК-ийн /Nomura securities co. ltd/
Зуучлалын гэрээ	2013.12.13	Хөгжлийн банк	Мизухо банк ХХК /Mizuho bank, ltd/
Эзэмшигчдэд үнэт цаасны мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх бүхий компанитай байгуулах гэрээ	2013.12.17	Хөгжлийн банк	ЯОУХАБ, Мизухо банк ХХК /Mizuho bank, ltd/
Бондын нөхцөл	2013.12.25	Хөгжлийн банк	Японы Үнэт Цаасны Хадгаламжийн Төв компани /ЯҮЦХТ/

ЯОУХАБ Хөгжлийн банкнаас гаргасан Самурай бондын үндсэн төлбөрт 100 хувь, хүүгийн төлбөрт 95 хувийн баталгаа гаргахыг зөвшөөрч зээлийн баталгааны төлбөр болон гаргалтын зардалд бондын орлогоос дунджаар жилийн 2.075 хувь буюу нийт 5.7 тэрбум иен суутган авсан байна.

### Хөгжлийн банкны тухай

Засгийн газар 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолоор Хөгжлийн банк байгуулахаар шийдвэрлэж, УИХ-аас Хөгжлийн банкны тухай хуулийг 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталжээ.

Дээрх хуулиар Хөгжлийн банк Монгол Улсын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх зорилго бүхий үйл ажиллагаа эрхлэх тусгайлсан чиг үүрэгтэй, ашгийн төлөө, төрийн өмчит хуулийн этгээд байхаар заажээ.

Засгийн газрын 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор Хөгжлийн банкны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг баталж, хуулийн дагуу албан ёсоор үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхэлсэн байна.

2010 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд Хөгжлийн банкны дүрмийн санг 16.7 тэрбум төгрөгөөр тогтоож, 2010 оны 12 сард Сангийн сайдын 283 дугаар тушаалын дагуу банкны дүрмийн санг бүрдүүлсэн.

Жил бүр төсвийн тухай хуулиар Хөгжлийн банкны дүрмийн санг нэмэгдүүлж ирсэн байна:

Хүснэгт 4

Он	Үндэслэл	Мөнгөн дүн <i>/тэрбум төгрөгөөр/</i>
	Дүрмийн сан /2010.07.09/	16.7
2011 он	Төсвийн тухай хууль	+33.0
2012 он	Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль	+23.6
2013 он	Төсвийн тухай хууль	+50.0
2014 он	Төсвийн тухай хууль	+20.6
	Дүрмийн сан /2014.12.31/	143.9

Хөгжлийн банкны дүрмийн санг 2011-2014 оны Төсвийн тухай хуулиар нийт 127.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ.

#### **Төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх шийдвэрийн талаар**

УИХ 2011 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар Хөгжлийн банкны тухай хууль болон УИХ-ын "Зээлийн баталгааны дээд хэмжээ тогтоох тухай" 14, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 15 дугаар тогтоолуудыг баталжээ.

Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтыг үндэслэн УИХ-аас баталсан "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 15 дугаар тогтоолоор дараах төсөл, хөтөлбөрүүдийг Хөгжлийн банкны санхүүжилтээр 2011 оноос хэрэгжүүлж эхлэхийг Засгийн газарт даалгасан байна. Үүнд:

1. УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр,
2. УИХ-ын 2010 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого",
3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2010 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 45 дугаар тогтоолд заасан "Сайншанд" аж үйлдвэрийн цогцолбор,
4. УИХ-ын 2008 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 47 дугаар тогтоолоор баталсан "Өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа нөхцөлтэйгээр барих авто зам, эрчим хүчний барилга, байгууламжийн жагсаалт"

Дээрх тогтоолоос өөр Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан шаардлагын дагуу Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл хөтөлбөрийн жагсаалтыг УИХ-ын хаврын чуулганаар жил бүр баталж байгаагүй байна.

Чингис бондын зарцуулалтын талаар ҮАБЗ-өөр хэлэлцэж 2012 оны 28/20 тоот, 2014 оны 19/10 тоот зөвлөмжөөр МУЗГ-т 14 үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвлөжээ.

Засгийн газраас 2011-2014 онуудад бүгд 56 тогтоолоор Хөгжлийн банкны нийт эх үүсвэрээс 292 төсөл /"888" төслийг 1 төсөл гэж тооцоход/-д 2,171.1 тэрбум төгрөг, 1,697.2 сая ам.доллар, 13.1 сая еврогийн зээл олгохоор шийдвэр гарчээ.



Засгийн газрын тогтоолоор санхүүжүүлсэн төсөл хөтөлбөр нийт дүнгээр: *Хүснэгт 5*

ЗГ-ын тогтоолоор шийдвэрлэгдсэн дүн			Хөгжлийн банкнаас олгосон дүн			Санхүүжигдээгүй үлдэгдэл		
Тэрбум төгрөг	Сая ам.доллар	Сая евро	Тэрбум төгрөг	Сая ам.доллар	Сая евро	Тэрбум төгрөг	Сая ам.доллар	Сая евро
2171.1	1697.2	13.1	1860.5	1144.4	8.2	310.6	552.8	4.9

Дээрх Засгийн газрын тогтоолуудаас Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн санхүүжилтэд 438.7 тэрбум төгрөгийн, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд 55.0 сая ам.долларын, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор төслийг хэрэгжүүлэхэд 14.2 тэрбум төгрөгийн, аймгийн төвүүдийг нийслэлтэй холбох авто замын төслүүдийг хэрэгжүүлэхэд 1,097.0 тэрбум төгрөгийн санхүүжилтыг Хөгжлийн банкны эх үүсвэрээс олгох шийдвэр гаргажээ.

Эдгээрээс 11 төсөл, хөтөлбөрт нийт 2,861.8 тэрбум төгрөгийг Чингис бондоос, 20 төсөл, хөтөлбөрт нийт 1,977.7 тэрбум төгрөгийг Хөгжлийн банк/*Самурай, Евро бонд, бусад*-ны эх үүсвэрээс санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын тогтоолуудад төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх болон хэрэгжүүлэх байгууллага, олгох мөнгөн дүн, хугацааг шууд заасан, түүнчлэн эрсдэл, үр ашгийг нарийвчлан судалж тодорхойлоогүй төсөл арга хэмжээ нилээд орсон байна.


ТБОНӨХБАУХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.6-д *"Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй"* гэж заасныг үндэслэн гаргасан Засгийн газрын тогтоолд нэр заасан компаниудтай Хөгжлийн банк шууд гэрээ байгуулж, санхүүжүүлж байна. Харин жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зээлийг арилжааны 11 банкаар дамжуулан олгох үйл ажиллагаа явуулсан байна.

Төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагыг Засгийн газрын шийдвэрт шууд заасантай холбогдон Хөгжлийн банкны үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулахад зарим хүндрэл гарч, зээлийн үндсэн зарчим болох зээлийн судалгаа хийж эрсдэл, үр ашгийг тодорхойлох, хөгжлийг дэмжих үр ашигтай, эрсдэлгүй, эргэн төлөгдөх баталгаа бүхий төсөл, хөтөлбөрийг болон хэрэгжүүлэгчийг сонгон санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж байсан байна.

## БҮЛЭГ ХОЁР. ЧИНГИС БОНД, САМУРАЙ БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Хөгжлийн банк нь Дүрмийн сангийн 143.9 тэрбум төгрөг, Евро бондын 580.0 сая ам.доллар, Чингис бондын 1.49 тэрбум ам.доллар, Самурай бондын 24.2 сая иен болон бусад эх үүсвэрийг оролцуулан нийт 5.6 их наяд төгрөгийн эх үүсвэртэйгээр үйл ажиллагаа явуулсан байна. Үүнд:

График 1



### Чингис бонд /Засгийн газрын бонд/

Чингис бондын 1.49 тэрбум ам.доллар 2012 оны 12 дугаар сарын 5-ны өдөр Монголбанк дахь Засгийн газрын дансанд орсон бөгөөд Сангийн яамны Төрийн сангийн газар мөн өдөр улсын гадаад өрийн хэмжээг дээрх дүнгээр нэмэгдүүлэн бүртгэжээ.

ЭЗХЯ, Монгол банк, Сангийн яамны 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 05/12/445 тоот гурвалсан гэрээний дагуу Чингис бондын 1.49 тэрбум ам.долларыг Монголбанк дахь Засгийн газрын бондын харилцах дансанд жилийн 4.7917 хувийн хүүтэйгээр байршуулсан. Энэ гэрээний дагуу 2013 онд Монгол банкаас 88.1 тэрбум төгрөгийн хүүг Сангийн яаманд төлсөн байна.

Сангийн яам, ЭЗХЯ /хөрөнгө эзэмшигч/, Хөгжлийн банк харилцан тохиролцож 2013 оны 4 дүгээр сарын 30-ний өдрийн 01/12/3/88 тоот гурвалсан "Санхүүгийн зуучлалын гэрээ"-г байгуулсан. Уг гэрээнд Санхүүгийн зуучлалын хүрээнд хөрөнгө эзэмшигч талууд нь 1.5 тэрбум хүртлэх ам.доллар болон түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн эх үүсвэрийг жилийн 4.7917 хувийн хүүтэйгээр тухай бүрт Хөгжлийн банкинд байршуулахаар заасан байна.

Сангийн яам гэрээний дагуу Хөгжлийн банкнаас 2013 онд 31.3 тэрбум төгрөг, 2014 онд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон зээлийн хүүг суутгаж, үлдэгдэл 75.6 тэрбум төгрөгийг авсан тооцоо гарч байна.

Засгийн газар 2013, 2014 онд бондын хүүгийн төлбөрт 229.7 тэрбум төгрөгтэй тэнцэх 135.1 сая ам.долларыг шилжүүлжээ. Хүснэгтээр харуулвал:

Хүснэгт 6

Он	Монгол банкнаас СЯ-нд төлсөн хүү	Хөгжлийн банкнаас СЯ-нд төлсөн хүү	СЯ хүлээж авсан хүүгийн орлого бүгд	СЯ-наас бондын төлбөрт төлсөн хүү
2013 он	88,100.08	31,374.30	119,474.38	98,984.40
2014 он	-	75,606.84	75,606.84	130,744.10
	88,100.08	106,981.14	195,081.22	229,728.5

/2013.12.31-ний МБ-ны албан ханш 1659.34, 2014.12.31-ны МБ-ны албан ханш 1888.44/

Засгийн Газраас гаргасан Чингис бондын хөрөнгийг Хөгжлийн банкны нэхэмжлэлийн дагуу Сангийн яамны Монголбанк дах данснаас нийт 2,021.25 тэрбум төгрөг, 269.89 сая ам.долларыг 10 удаагийн гүйлгээгээр шилжүүлсэн байна.

### ЧИНГИС БОНДЫН ХӨРӨНГӨӨС ХҮЛЭЭН АВСАН ЭХ ҮҮСВЭР

ХҮСНЭГТ 7

ОГНОО	ханш	/төгрөгөөр/	/ам.доллараар/	нийт /ам.доллараар/	нийт /төгрөгөөр/
2013.05.06	1432.81		84,740,000.00	84,740,000.00	159,785,744.00
2013.05.10	1436.87	52,705,236,479.56	1,939,041.00	38,619,629.00	56,361,492,189.16
2013.05.28	1441.93	253,999,999,694.35		176,152,795.00	253,999,999,694.35
2013.07.16	1461.23		73,210,000.00	73,210,000.00	138,044,776,000.00
2013.08.09	1570.32	390,870,000,036.00		248,911,050.00	390,870,000,036.00

2013.10.02	1650.04	411,619,999,774.76		249,460,619.00	411,619,999,774.76
2013.11.21	1746.01	431,570,499,999.60		247,175,273.91	431,570,499,999.60
2013.11.27	1746.59		110,000,000.00	110,000,000.00	207,416,000,000.00
2014.03.17	1764.8	355,060,000,005.79		201,189,936.54	355,060,000,005.79
2014.04.08	1778.05	125,424,885,500.73		70,540,696.55	125,424,885,500.73
НИЙТ	1,643.14	2,021,250,621,490.79	269,889,041.00	1,500,000,000.00	2,530,153,397,200.39

Сангийн яам нь Хөгжлийн банкинд 1,230.1 сая ам.долларын Чингис бондын хөрөнгийг төгрөгөөр тооцон шилжүүлснээс 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тухайн дүнд 302.6 тэрбум төгрөгийн ханшийн эрсдэл хүлээх тооцоо гарч байна.

**Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн үйл ажиллагааны зардалд 1 хувийн хүү нэмж төлж байна**

Хөгжлийн банк Засгийн газрын тогтоолоор 11 төсөл, хөтөлбөрт 1,320.3 тэрбум төгрөгийн зээл олгосноос 2014.12.31-ны өдрийн байдлаар 1,288.2 тэрбум төгрөгийн, 347.8 сая ам.долларын зээлийг олгосноос 266.4 сая ам.долларын зээлийн үлдэгдэлтэй байна.


Хүснэгт 8

	төгрөгөөр	ам.доллараар	Нийт төгрөгөөр
Чингис бондын эх үүсвэр	2,021,250,621,490.79	269,889,041.00	2,530,153,397,200.39
Олгосон зээлийн үлдэгдэл	1,288,221,612,654.65	266,434,937.45	1,790,601,416,710.37
Эх үүсвэрийн үлдэгдэл	733,029,008,836.14	3,454,103.55	739,542,066,490.02

/ам.долларыг Монголбанкны тухайн үеийн албан ханшаар шилжүүлэн тооцов/

Ам.доллараар олгосон зээлийг 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголбанкны тухайн өдрийн зарласан албан ханшаар хөрвүүлэн тооцсоноор нийт 1,790.6 тэрбум төгрөгийн зээлийн, 739.5 тэрбум төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Чингис бондоос олгосон зээлийн 55.7 хувь нь Улсын төсвөөс эргэн төлөгдөх, 44.3 хувь нь төсөл хэрэгжүүлэгчээс эргэн төлөгдөх нөхцөлтэй байна. Бондын хөрөнгийн санхүүжилтийн зураглалыг харуулвал:



Хөгжлийн банкнаас дээрх, төсөл хөтөлбөрүүдэд зээл олгохдоо үйл ажиллагааны зардлыг нөхөх 1 хувиар нэмэгдүүлж зээлийн хүүг тооцож байгаа бөгөөд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн жилийн жигнэсэн дундаж хүү төгрөгийн зээлд 7.23, ам.долларын зээлд 6.16 хувь байна.

Хөгжлийн банк Чингис бондын зарцуулагдаагүй үлдэгдлийг арилжааны банкуудад дараах байдлаар байршуулсан байна:

Хүснэгт 9 /2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/

Банк	Жилийн дундаж хүү	Хадгаламж		Нийт хадгаламж /төгрөгөөр/
		/төгрөгийн/	/ам.долларын/	
Худалдаа Хөгжлийн банк	10.96%	315,532,305,141.29		315,532,305,141.29
Улаанбаатар хотын банк	10.29%	165,824,704,768.40	1,515,243.54	168,681,847,984.49
Төрийн банк	13.30%	133,962,343,516.04		133,962,343,516.04
Хаан банк	14.48%	97,081,023,542.27		97,081,023,542.27
Капитрон банк	14.33%	7,422,106,560.22		7,422,106,560.22
Чингис хаан банк	14.31%	6,679,895,904.20		6,679,895,904.20
ҮХОБанк	14.91%	6,526,629,403.73		6,526,629,403.73
Голомт банк	6.70%		1,629,294.13	3,072,197,006.55
Капитал банк	6.80%		309,565.88	583,717,431.24
Нийт хадгаламж		733,029,008,836.14	3,454,103.55	739,542,066,490.02

Хүснэгтээс харахад төгрөгийн хадгаламжийг дунджаар жилийн 11.95%, ам.долларын хадгаламжийг жилийн 6.75% хүүтэйгээр байршуулжээ.

**Самурай бонд /Засгийн газрын баталгаатай Хөгжлийн банкны бонд/**

Самурай бонд арилжаалах гэрээний дагуу Монголбанк дахь Хөгжлийн банкны харилцах дансанд 2014 оны 1 дүгээр сарын 6-ны өдөр 24.2 тэрбум иен орж иржээ. Самурай бондын санхүүжилтийг хүснэгтээр харуулвал:

Хүснэгт 10		/төгрөгөөр/
Самурай бонд	30,000,000,000.0 /иенээр/	472,200,000,000.0
Самурай бондтой холбоотой зардал	5,749,785,692.0 /иенээр/	90,501,626,792.1
Самурай бондын шилжиж ирсэн эх үүсвэр	24,250,214,308.0 /иенээр/	381,698,373,207.9
Нийт олгосон зээл	76,414,100.00 /ам.доллараар/	144,237,274,960.0
		262,740,591,179.0
2014.12.31-ний үлдэгдэл		(25,279,492,931.0)

Хөгжлийн банкны 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн зээлийн мэдээнд Засгийн газрын 2014 оны 184, 185, 230, 237, 217 дугаар тогтоолуудыг үндэслэн 262.7 тэрбум төгрөг, 166, 116, 152 дугаар тогтоолуудыг үндэслэн 76.4 сая ам.долларын зээл олгосноор бүртгэсэн байна. /зээлийн дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/

Самурай бондоос олгосон зээлийн 33.1 хувь нь Улсын төсвөөс эргэн төлөгдөх, 66.9 хувь нь төсөл хэрэгжүүлэгчээс эргэн төлөгдөх нөхцөлтэй бөгөөд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн жилийн дундаж хүү төгрөгийн зээлд 7.34, ам.долларын зээлд 6.5 хувь байна.

**Хөгжлийн банкны активын удирдлагын талаар**

Хөгжлийн банкны нийт активын 3,809.1 тэрбум төгрөгийг зээлийн эх үүсвэрт ашигласан бөгөөд чөлөөт үлдэгдэл болох нийт 1,273.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг ЗГ-ын 2012 оны 8 дугаар тогтоолоор гаргасан шийдвэрийн дагуу богино /1 сар хүртлэх/ болон дунд /6 сар хүртлэх/ хугацаатайгаар Төв банк болон Засгийн газрын үнэт цаас, арилжааны банкуудад векселээр баталгаажсан хадгаламж хэлбэрээр байршуулж байсан.

Засгийн газрын 8 дугаар тогтоолоор Сангийн яам, Хөгжлийн банк хооронд байгуулсан “Засгийн газрын баталгааны үндсэн нөхцөлийг тохиролцох гэрээ”-нд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн, харин Монголбанктай хамтран ажиллах ямар нэг эрх зүйн зохицуулалтгүй байна.

Активын бүтцийн хувьд зээлийн үлдэгдэл 60 орчим хувийг, арилжааны банкуудад байршуулсан хөрөнгө 30 орчим хувийг, үлдэх 10 орчим хувийг бусад хөрөнгийн дүн эзэлж байна.



2014 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар арилжааны банкуудад байршуулсан хадгаламжын үлдэгдэл 1,273.9 тэрбум төгрөг байгаа ба тэдгээрийн жигнэсэн дундаж хүү 2012 онд 9.74, 2013 онд 9.55, 2014 онд 10.47 хувьтай байна.

Активын удирдлагын хувьд чөлөөт эх үүсвэрийг ямар байгууллагад, хэрхэн, ямар шалгуураар, ямар нөхцлөөр байршуулах асуудлыг зохицуулсан журам байхгүй байна.

Төгрөгийн хадгаламжийн 43 хувийг ХХБ, 23 хувийг УБХБ, 18 хувийг Төрийн банк, 13 хувийг Хаан банкинд үлдэх 5 хувийг бусад арилжааны банкуудад байршуулсан байна.

Мөн ам.долларын 47 хувийг Голомт банкинд, 44 хувийг УБХБ, иенийн 50 хувийг Голомт банкинд, 13 хувийг Капитал банкинд, 10 хувийг Хас банкинд, 5 хувийг Хаан банкинд, 22 хувийг ХХБ, еврогийн 20 хувийг Голомт банкинд, 80 хувийг Капитал банкинд хадгаламж хэлбэрээр байршуулсан байна.

Эдгээр банкуудын активын хэмжээг авч үзвэл: банкны системийн нийт активын 26.1 хувийг ХХБ, 24.5 хувийг Хаан банк, 19.1 хувийг Голомт банк эзэлж байгаа бол УБХБ 6.2 хувийг, Капитал банк 2.8 хувийг эзэлж байна.

Банкны нэр	Активын хэмжээ	
	/тэрбум төгрөгөөр/	Хувиар
1 ХХБ	5,124.10	26.1
2 ХААН банк	4,801.00	24.5
3 Голомт банк	3,749.80	19.1
4 Төрийн банк	1,754.30	9.0
5 Хас банк	1,811.50	9.2
6 УБХ банк	1,214.10	6.2
7 Капитал банк	554.90	2.8
8 Капитрон банк	204.40	1.0
9 Ариг банк	57.40	0.3
10 Чингис хаан банк	215.10	1.1
11 ҮХОБанк	101.50	0.5
12 Кредит банк	12.20	0.1
Нийт дүн	19,600.30	

Хүснэгт 11. Арилжааны банкнуудын активын хэмжээ  
График 3. Банкны системийн зээлийн хэмжээ



## Евро Бонд

Хөгжлийн банк өрийн бичгээ олон улсын зах зээлд арилжаалах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд 2011 оны 11 дүгээр сарын 30-нд 600.0 сая ам.долларын Дунд хугацааны евро бондын хөтөлбөр /ДХЕБХ/-ийг хэрэгжүүлж эхэлжээ.

Энэ хөтөлбөрийн хүрээнд 20.0 сая ам.долларын, жилийн 6 хувийн хүүтэй, 1 жилийн хугацаатай үнэт цаасыг хаалттай хэлбэрээр олон улсын зах зээлд 2011 оны 12 дугаар сарын 9-ний өдөр арилжаалсан, мөн 2012 оны 3 дугаар сарын 21-ний өдөр 5 жилийн хугацаатай 5.75 хувийн хүүтэй 580.0 сая ам.долларын бондыг олон улсын зах зээлд арилжаалсан ч бондын хөрөнгийг зарцуулах ажлын бэлтгэл хангагдаагүй, түүнийг арилжааны банкуудад байршуулах асуудал журамлагдаагүй, хөрөнгө байршуулах тогтоол шийдвэр байхгүйтэй холбоотойгоор 6 сарын турш аливаа хүүний орлогогүйгээр сул эх үүсвэр байршсан байна.

Дээрх хугацаанд Хөгжлийн банк 16.7 сая ам.долларын хүүгийн өглөгийг бүртгэсэн бөгөөд арилжааны банкуудад тухайн үеийн хамгийн бага хүүтэйгээр байршуулсан бол 14.5 сая ам.долларын орлого олох боломжоо алдсан тооцоо гарч байна.

## Кредит Свисс банкны зээл

Засгийн газрын 2014 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 117, Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн 2014 оны 8 сарын 29-ны өдөр Хөгжлийн банк, Кредит Свисс банктай 300.0 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулсан.

Зээлийн санхүүжилтийн эхний хэсэг болох 5 жилийн хугацаатай, 6 сарын лайбор+4.375 хувийн хүүтэй 185.0 сая ам.долларыг 2014 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр, үлдэгдэл хэсэг болох 3 жилийн хугацаатай, 6 сарын лайбор+4.25 хувийн хүүтэй 115 сая ам.долларыг 2014 оны 12 дугаар сарын 19-ны өдөр Хөгжлийн банк хүлээн авсан.

Зээлийн хөрөнгөнөөс Засгийн газрын 2014 оны 274 дүгээр тогтоолд заасны дагуу Оюутолгой төслийн санхүүжилтийн үр ашигтай байдлыг хангах, төслийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай стратеги, санхүү, хууль болон олон нийтийн харилцах үйлчилгээнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх зорилгоор Эрдэнэс-Оюутолгой ХХК-д 260.0 мянган ам.долларыг жилийн 7.65 хувийн хүүтэйгээр 2 жилийн хугацаатай олгож, үлдэгдэл нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны банкинд байршиж байна.

#### ***БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл***

Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 116, Хөгжлийн банкны ТУЗ-ийн 2014 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Хөгжлийн банкнаас төсөл санхүүжүүлэх эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор БНХАУ-ын Хөгжлийн банкнаас жилийн 6 хувийн хүүтэй, 8 жилийн хугацаатай 162.0 сая ам.долларын зээлийн гэрээ байгуулсны санхүүжилтийн эхний хэсэг болох 112.0 сая ам.долларыг 2014 оны 9 дүгээр сарын 4-ны өдөр Хөгжлийн банк дансандаа хүлээн авч, эрчим хүчний салбараас хэрэгжүүлж буй төслүүдийг санхүүжүүлжээ.

## БҮЛЭГ. ГУРАВ. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР


2014 оны 12 дүгээр сарын 31-ны өдрийн байдлаар Хөгжлийн банкнаас олгосон зээлийн үлдэгдэл 3,809.1 тэрбум төгрөг байна.

### Эх үүсвэрийн бүтэц



График 4

### Зээлийн эргэн төлөгдөх бүтэц



Зээлийн багцыг эргэн төлөгдөх нөхцлөөр нь авч үзвэл, нийт зээлийн багцын 55.7% буюу 2,120.4 тэрбум төгрөгийн зээл нь улсын төсвөөс, 44.3% буюу 1,688.7 тэрбум төгрөгийн зээл нь төсөл хэрэгжүүлэгчээс эргэн төлөгдөх нөхцөлтэй байна.


### Зээлийн багцын мэдээ

Хөгжлийн банкны нийт зээлийн багцын дэлгэрэнгүйг 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хавсралт 1-д үзүүлэв.

Хөгжлийн банкны зээлийн багцыг эх үүсвэрээр нь авч үзвэл, Чингис бонд /1.5 тэрбум ам доллар/, Дунд хугацааны евро бонд /580.0 сая ам доллар/, Самурай бонд /24.3 тэрбум иен/, Коммерц банкны эх үүсвэр /13.1 сая евро/, Кредит Свисс банкны зээл /300.0 сая ам доллар/ БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл /112.0 сая ам доллар/ болон өөрийн хөрөнгө /277.5 тэрбум төгрөг/-ийн эх үүсвэрээс тус тус санхүүжилт хийгдсэн байна.

Зээлийн багцыг эдийн засгийн салбараар нь авч үзвэл, нийт зээлийн багцын 29.6%-ийг авто зам, 2.4%-ийг Гудамж төсөл, 6.1%-ийг дэд бүтэц, 5.7%-ийг цахилгаан станц, 14.4%-ийг төмөр зам, 6.3%-ийг орон сууцны барилга, зээлийн санхүүжилт, 6.3%-ийг ХАА, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт, 6.0%-ийг барилгын материалын үйлдвэрлэл, 5.8%-ийг экспортыг дэмжих, импортыг орлох 888, 12.9%-ийг уул уурхай, 1.6%-ийг арьс ширний үйлдвэрлэл, 1.1%-ийг ЖДҮ сангийн төсөлд болон 1.9%-ийг бусад салбарт тус тус олгосон байна.

График 5




### Цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт олгосон зээлийн талаар

Хөгжлийн банкнаас цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарыг шинэчлэх, өргөтгөх, бааз суурийг бэхжүүлэх 4 төсөлд зориулан зээл олгосон ба 2014 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар тэдгээрээс 2 нь графикт хугацаандаа ашиглалтад орж, 1

нь ашиглалтад орох шатандаа, 1 нь төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа бусад ажлаас шалтгаалан 2015 онд ашиглалтад орохоор хугацаа хойшилсон байна.

### **Дулааны III цахилгаан станцын турбины өргөтгөлийн төсөл**



Засгийн газрын 142 дугаар тогтоолоор Дулааны III цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төсөлд 35.0 сая ам.долларын санхүүжилтийг Хөгжлийн банкнаас олгохыг даалгасан. Уг тогтоолын хүрээнд Хөгжлийн банкнаас төслийн гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгож буй бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 35 сая ам.долларын зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн зарцуулалтыг газар дээр шалгаж үзэхэд дулааны III цахилгаан станцын хүчин чадлыг 50 МВт-аар өргөтгөх төсөл хэрэгжиж

2014 оны 6 дугаар сарын 16-нд ашиглалтад хүлээн авсан байна.

### **Дулааны IV цахилгаан станцын өргөтгөлийн төсөл**

Засгийн газрын 2012 оны 99, 119 дүгээр тогтоолуудаар Дулааны IV цахилгаан станцын хүчин чадлыг 100 МВт-аар өргөжүүлэх төсөлд 70.0 сая ам.долларын санхүүжилт олгохыг Хөгжлийн банкинд даалгасан.

2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 59.7 сая ам.долларын зээлийн үлдэгдэлтэй байна. Газар дээр очиж зээлийн зарцуулалтын үйл ажиллагаатай танилцахад ажлын гүйцэтгэл 90 орчим хувьтай байна.



### **Амгалан дулааны станцын ашиглалтад орох хугацаа хойшилсон нь Засгийн газрын байгууллагуудын ажлын гүйцэтгэлээс шалтгаалжээ**



БНХАУ-ын Хөгжлийн банкны зээлийн асуудал шийдвэрлэгдэх хүртэл төсөлд 25.0 сая ам.долларын гүүрэн зээл<sup>1</sup> олгохоор Засгийн газрын 2014 оны 166 дугаар тогтоолын дагуу Хөгжлийн банкнаас зээлийг олгосон ба аудитын явцад газар дээр нь очиж судлахад Засгийн газраас хэрэгжүүлэх зарим ажлын гүйцэтгэл хангалтгүйгээс 2015 онд ашиглалтад орохоор байна.

### **Багануур ХК-ийн тоног төхөөрөмжийн шинэчлэлийн төсөл**



Засгийн газрын 2013 оны 10, 283 дугаар тогтоолуудын дагуу Багануурын уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор тоног төхөөрөмж худалдан авах болон нүүрс бутлан ачих байгууламжийн өргөтгөлийн төслийг хэрэгжүүлэхэд зориулж нийт 18.6 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосон ба төслийн дагуу Багануур ХК нь нүүрс олборлолтын хүчин чадлаа нэмэгдүүлснээс гадна нүүрс бутлан ачих

байгууламжийн өргөтгөлийн төслийг дуусгасан байна.

<sup>1</sup> Тухайн төслийн дараагийн санхүүжилтын шийдвэр гартал түр хугацаанд олгож буй зээл



## **Уул уурхай, төмрийн хүдрийн төслүүд гадаад зах зээл дэх хүдрийн үнийн уналтаас эрсдэл хүлээж болзошгүй байна**

Уул уурхай, төмрийн хүдэр боловсруулалтын салбарыг дэмжих, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 256 дугаар тогтоолын дагуу Монгол металл майнинг холдинг ХХК, Монголросцветмет ХХК, Монлаа ХХК, Бэрэн ХК-иудад 50.0 сая ам.долларын санхүүжилт олгохоор баталжээ.



Дээрх тогтоолын дагуу Бэрэн групп ХХК-д 12.8 сая ам.долларын зээлийг олгосон ба Орхон аймагт 100 мянган тонн төмөр боловсруулах хүчин чадалтай арматурын үйлдвэрийг 2015 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна.


Мөн Мон-Лаа ХХК-д 3.0 сая ам.долларын зээлийг төмрийн хүдрийн баяжуулах үйлдвэр барих зориулалтаар олгосон ба зээлийг БНХАУ-ын Shu Guang Jia Gong /Шу Гуан Жиа Гун/ компани руу тоног төхөөрөмж худалдаж авах зориулалтаар шилжүүлжээ.

Их үүсгэл ХХК-ийн үл хөдлөх хөрөнгийг Мон Лаа ХХК-ийн зээлийн барьцаанд бүртгэсэн ба барьцаа хөрөнгийн үнэлгээ нь ирээдүйд эрсдэл үүсгэж болзошгүй байна.

Монголросцветмет ХХК, Монгол металл майнинг холдинг ХХК-иудын зээл Зээлийн хорооноос батлагдсан хэдий ч дотоод үйл ажиллагаанаасаа шалтгаалан тухайн зээлийг аваагүй байна.

### **Барилгын салбарт олгосон зээл**

Барилгын салбарт Хөгжлийн банкнаас хоёр төсөл санхүүжүүлж байгаа ба ТОСК-аар дамжуулан 111.9 тэрбум төгрөгийн Буянт Ухаа I, II төсөл, "Пи Ай Эм Эм" ХХК-иар дамжуулан 20.0 тэрбум төгрөгийн Шинэ яармаг хорооллыг барьж байна.



ТОСК Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан иргэдийг хямд үнэтэй орон сууцаар хангах зорилтын хүрээнд Буянт Ухаа I, II төслийг үндэсний бүтээн байгуулалтын 6 компаниар тухайн ажлыг гүйцэтгүүлж 1 мкв-ын үнийг дунджаар 1,300.0 мянган төгрөгөөр борлуулж байна.

Барилгын салбарын борлуулалтыг дэмжих зорилгоор 4000 төрийн албан хаагчдын орон сууцны хөтөлбөрийг дэмжихэд зориулж Төрийн банкинд 30.0 тэрбум төгрөгийн зээл олгожээ.

Мөн барилгын үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр "Эрэл" ХХК-ийн хэрэгжүүлж буй БҮК-1 төсөлд зориулж 14.2 сая ам.долларын зээл олгосны дагуу ХБНГУ-ын тоног

төхөөрөмжөөр үйлдвэрлэл явуулахаар суурилуулалтын үйл ажиллагаагаа явуулж байна.

### ***Хөрөнгийн биржэд олгосон зээл***

Засгийн газрын 2014 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Монгол улсын хөрөнгийн биржид 1.49 сая ам.долларын зээлийг улсын төсвөөс эргэн төлөх 1 жилийн хугацаатай жилийн 7 хувийн хүүтэй, хугацааны эцэст зээл, хүүгийн төлбөрийг төлөх нөхцөлтэйгөөр олгогдсон.

Засгийн газраас Сангийн сайдад 2012 оны төсвийн тодотголд тухайн зээлийн санхүүжилтийг оруулахыг даалгасан боловч тусгагдаагүй, Хөгжлийн банк хамтран ажиллах мастер гэрээндээ зээлийг хариуцаж төлнө гэсэн заалт байгаа боловч өөрийн орлогоос зээл эргэн төлөгдөөгүй байна.

### ***Эрдэнэс-Тавантолгой ХХК-д өгсөн зээл***

Эрдэнэс тавантолгой ХХК-ийн эргэлтийн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор 200.0 сая ам.долларыг зээлэх эрхийг Хөгжлийн банкны ТУЗ-д зөвшөөрчээ.

Хөгжлийн банк Эрдэнэс Тавантолгой ХК-тай 2012 оны 10 дугаар сарын 05-ны өдөр байгуулсан ЗТЗБ-2012-144 тоот зээлийн гэрээний дагуу 100.0 сая ам.доллар, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан З-ЭТ-ХО 2012-162 тоот зээлийн гэрээний дагуу 100.0 сая ам.доллар, нийт 200.0 сая ам.долларын зээлийг бондын хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн ба харин Засгийн газрын 2013 оны 319 дүгээр тогтоолоор компанийн давуу эрхтэй хувьцаагаар солихоор шийдвэрлэсэн байна.

Хөгжлийн банк Эрдэнэс Тавантолгой ХК-тай 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдөр З-ЭТ-2014-210 тоот Зээлийн гэрээ, Б-ЭТ-Э20141 тоот Зээлдэгчийн харилцах данс барьцаалах тухай гэрээ, 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Сангийн яамтай БД-ЭТ-Э2014-210 тоот Батлан даалтын гэрээг тус тус байгуулан 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 50.0 сая ам.долларын зээлийг нэмж олгожээ.

### ***Бондын хөрөнгөөр санхүүжиж буй ҮХААЯ-ны төслүүдийн үйл ажиллагаа зогсонги байдалтай байна***

Засгийн газрын 2013 оны 126, 141 дүгээр тогтоолуудаар техник тоног төхөөрөмжийн санхүүжилтийн эх үүсвэрийн гуравны нэгтэй тэнцэх урьдчилгаа төлбөрийг 4,5 жилийн хугацаатай нийт 172.4 сая ам.долларыг зээлээр олгохыг Хөгжлийн банкинд зөвшөөрсөн байна.

Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх, Монгол улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор 2013 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Хөгжлийн банк ҮХААЯ болон Голомт банкны хамтран ажиллах гэрээг байгуулж, 269.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Голомт банкинд олгосон.

Техник тоног төхөөрөмжийн шинэчлэх зорилгоор Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны дэргэд ноос, ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл, өвлийн хүлэмжийн аж ахуй, сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, оёдол, оёмол бүтээгдэхүүн үйлдвэрлэл гэсэн 5 төслийн нэгж үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна.

Төслийн нэгжүүд нь төсөл сонгон шалгаруулах баримт бичиг боловсруулах, төсөл сонгон шалгаруулах, тухайн салбарын зах зээлийн судалгаа хийх, бондын хөрөнгөөр санхүүжих төслийн хэрэгжилт, ашиглалт, үр дүнд хяналт тавих, санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгчдийн ажлын уялдаа холбоог хангах зэрэг үүргийг гүйцэтгэж байсан байна.

Гэвч 2014 он гарсаар эдгээр төслүүд нь санхүүжилт аваагүй, одоогоор төслийн нэгжид ажиллаж байгаа хүнгүй, офиссийн байргүй, төслийн үндсэн хөрөнгө түүний дотор шинээр авсан автомашиныг хүлээлгэн өгсөн тодорхой газаргүй байна.

Төслийн нэгжүүдийн урсгал зардлын санхүүжилт төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусгагдаагүй бөгөөд үүнд шаардлагатай 1.7 тэрбум төгрөгийг жилийн 6 хувийн хүүтэйгээр 2014 оны улсын төсвөөс эргүүлэн төлөх нөхцөлтэйгөөр бондын хөрөнгөөс санхүүжүүлэхээр 2013 оны 8 дугаар сарын 26-ны өдөр ЭЗХЯ, ҮХААЯ, Хөгжлийн банк гурвалсан гэрээ байгуулсны дагуу дээрх 5 төслийн үйл ажиллагааны зардалд зарцуулагдсан байна.

Засгийн газрын 2014 оны 198 дугаар тогтоолоор 30.0 тэрбум төгрөгийг буцаан татсан бөгөөд Голомт банк нийт санхүүжилтийн 59.9 хувь буюу 143.1 тэрбум төгрөгийг ҮХААЯ-ны төслүүдэд олгосон, 40.9 хувь буюу 95.9 тэрбум төгрөгийн санхүүжилт тус банкинд байршиж байна.

### **Дэд бүтэц, эрчим хүчний төслийн талаар**

Техникийн нөхцөл аваагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ бэлэн болоогүй, төсөвт өртөг нэмэгдэж хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон төсөл арга хэмжээ байна. Тухайлбал,

- Дэд бүтэц-Эрчим хүч төслийн "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй 14.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй "Амгалан дулааны станцаас дулаан түгээх цэг хүртэлх 4 км шугамын барилга угсралтын ажлын зураг төсөл, төсөвт өртгийг бодитой тооцоогүйгээс 12.6 төгрөгөөр нэмэгдсэн;
- "ДЦС-4" өөс "У-18" хүртэл 4.2 км ф800-ийн голчтой дулааны шугамын 14.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлын төсөвт өртгийг бодитой тооцоогүйгээс нэмж 2.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн хэдий ч дахин 2.1 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй тохиолдолд гэрээнд заасан хугацаанд уг ажил бүрэн хэрэгжих боломжгүй болсон байна.
- Яармагийн гүүр орчмын хорооллын 110/35/10 кВ-ын 2х25 МВА чадалтай компьютерийн хяналт удирдлагын системтэй дэд станцын барилга угсралтын ажил 110 кВ-ын АС-240/39 дамжуулагч утастай, 2х2 шилэн кабель бүхий аяндын тростой ЦДАШ-ын зураг төсөл, барилга угсралтын 7.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын техникийн нөхцөл шийдэгдээгүй,
- Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын хэсэгчилсэн төлөвлөгөөнд өөрчлөлт орсонтой холбогдож Сонгинохайрхан дүүргийн Ханын материал орчмын гэр хорооллын дулааны 1.1 км шугам, ус дулаан дамжуулах төв, 137 метр шугам, бие даасан 9.3 Гкал чадалтай дулааны эх үүсвэр, гадна төв бохир усны 1235 метр шугам, бохир усны 1788 метр шугамын 9.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй зураг төсөл, барилга угсралтын ажил хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон байна.

Засгийн газрын 118 дугаар тогтоолоор Дэд бүтцийн төсөл нийт 14 төрлийн инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлыг гүйцэтгэхээр тусгагдсаны 2 ажил нь төсөл хэрэгжихээс өмнө гүйцэтгэсэн ажил байна. Үүнд:

- Яармагийн гүүр орчмын орон сууцны хорооллын бохир ус, дулаан, цахилгаан шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг Пума ХХК өөрийн хөрөнгөөр 2012 онд хийж гүйцэтгэснийг ТӨХ-ны 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 541 дүгээр тогтоолоор 8,867.4 сая төгрөгийн дулааны магистраль шугам, гүүрэн байгууламж, тулгуур баганыг "Улаанбаатар дулааны сүлжээ" ТӨХК-ийн үндсэн хөрөнгөд, НИТХ-ын 2013 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 92 дугаар тогтоолоор 3,802.0 сая төгрөгийн 2,3 км урттай гадны бохир усны шугам сүлжээг нийслэлийн өмчид бүртгэсэн байна.
- Ховд аймгийн төвийн 4200м<sup>3</sup> хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажлыг "Ховдын тулга" ХХК хийж гүйцэтгэхээр 2012 оны 6 дугаар сарын 20-ны өдөр ИШС-3/2012-24 дугаартай гэрээ байгуулж, 2013 оны 8 дугаар сарын 1-ны

өдөр ашиглалтанд оруулахаар гэрээнд заасан боловч гэрээний ерөнхий нөхцөлд болон тусгай нөхцөлд гэрээт ажлыг цаг хугацаандаа дуусгаагүйгээс хүлээх хариуцлагыг заагаагүй. 1,500.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий дээрх ажлын гүйцэтгэлд 1,201.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Дэд бүтэц төслийн гүйцэтгэсэн 12 ажлаас өнөөдрийн байдлаар 7 ажлыг Улсын комисс хүлээн авч ашиглалтанд орсон байна.

### **Дэд төслүүдийн үйл ажиллагаа уялдаагүй байна**

Баянголын амны орон сууцны хорооллын цахилгаан хангамжийн кабель шугамын зураг төсөл, барилга угсралтын 3 хэсэг ажил дууссан боловч Эрчим хүчний яамны захиалгаар хийгдэж буй 110/35/10 кв-ын "Баянгол" дэд станц нь эрчим хүчний үндсэн эх үүсвэрт холбогдоогүй, дулааны 500 мм-ийн төв шугам ашиглалтанд ороогүй улмаас ашиглагч байгууллагууд нь хүлээн авах боломжгүй шалтгаанаас гэрээт ажлыг туршилт, тохируулгад оруулж Улсын комисст хүлээлгэн өгөх ажил хойшилсон байна.

ЭХЯ-ны захиалгатай Улаанбаатар хотыг тойруулан татаж байгаа "Их тойрог" 110 кв-ын цахилгаан дамжуулах агаарын шугам болон 110/35/10 кв-ын дэд станцууд ашиглалтанд орсны дараагаар "Баянгол" дэд станц ашиглалтанд орсноор "Дэд бүтэц" төслийн гүйцэтгэсэн ажлууд тэжээлийн эх үүсвэртэй болох нөхцөл бүрдэнэ.

Дээрх нөхцөл байдлаас харахад БХБЯ болон ЭХЯ-ны хооронд ажлын уялдаа хангалтгүйгээс "Дэд бүтэц", "Дэд бүтэц-Эрчим хүч" төслүүдийн үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

### **Хөгжлийн банкинд гаргах Засгийн газрын баталгааны хэмжээ УИХ-ын 14 дүгээр тогтоолд заасан хувь хэмжээг хангаж байна**

Улсын Их Хурлын 2011 оны 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн "Засгийн газрын 2011 оны 85,322 дугаар тогтоолоор 600.0 сая ам.долларын үнэт цаас гаргахыг тус банкинд, уг үнэт цаасны үндсэн болон хүүгийн төлбөрт Засгийн газрын баталгаа гаргахыг Сангийн сайдад зөвшөөрсөн.

Энэхүү Засгийн газрын баталгаа бүхий Хөгжлийн банкны 600.0 сая ам.доллар хүртэлх хэмжээний үнэт цаасыг олон улсын зах зээлд гаргахтай холбоотойгоор Баталгааны гэрээ, Итгэмжлэлийн гэрээ, Агентын гэрээ, Хөтөлбөрийн гэрээ зэрэг үнэт цаасыг гаргахад шаардлагатай баримт бичгүүдэд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Сангийн сайд 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр гарын үсэг зурж, баталгаажуулжээ.

МИАТ ХХК-ийн худалдан авч буй Бойнг-767 300 ER онгоцны үнэ болох 114,4 сая ам.долларын төлбөрийг АНУ-ын EXIM банкнаас зээл авах хүртэл хугацаанд санхүүжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 137 дугаар тогтоол, тус банкны ТУЗ-ийн 2013 оны 5 дугаар сарын 1-ны өдрийн 19 дүгээр тогтоолын дагуу Хөгжлийн банк 78.55 сая ам.долларын жилийн 7.5 хувийн хүүтэй, 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр төлөх хугацаатай бондыг ХХБ-д арилжаалсан байна.

УИХ-ын **2011 оны 14 дүгээр тогтоолоор** Засгийн газраас Хөгжлийн банкинд гаргах зээлийн баталгааны дээд хэмжээ нь 2012 оны төсвийн жилд ДНБ-ний 18.8 хувиас хэтрэхгүй байхаар заасан бөгөөд ХБ-аас гаргасан 580.0 сая ам.долларын бонд нь 2012 оны ДНБ-ний 5.99 хувийг эзэлж байгаа дээрх шалгуурыг хангаж байна. /ДНБ 2012 онд 13944.2 тэрбум төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн МБ-ны албан ханш 1392.1 төгрөг/

УИХ 2012 оноос хойш Хөгжлийн банкинд гаргах Засгийн газрын баталгааны дээд хэмжээг тусгайлан тогтоогоогүй бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Хөгжлийн банкны эх үүсвэр 100 хувь Засгийн газрын баталгаатай байна.

## ДУГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна:

1. Засгийн газар Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д "...санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их хурал жил бүрийн хаврын чуулганаар батална" гэж заасныг хангаж ажиллаагүй байна.
2. Чингис бондын хөрөнгийн менежментийг Монгол банк 1.5 жилийн хугацаанд санхүүгийн зуучлалын гэрээний дагуу хариуцаж, хүүгийн төлбөрт 88.1 тэрбум төгрөгийг төлсөнөөр мөн хугацаанд төсөвт эрсдэл үүсэхгүй төлбөрийг гадагш төлөх боломж бүрдсэн байна.
3. Чингис бондын хөрөнгө 2014 оны 4 дүгээр сараас Хөгжлийн банкинд бүрэн шилжсэн ба мөн оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээлийн хүүг суутгаснаар 75.3 тэрбум төгрөгийн хүүгийн төлбөрийг төлсөн байна. Үүнтэй холбогдон Сангийн яам гадагш хүүгийн төлбөр төлөхөд 34.7 тэрбум төгрөгийг төсвөөс нэмж зарцуулсан байна.
4. Сангийн яам нь Хөгжлийн банкинд 1,230.1 сая ам.долларын Чингис бондын хөрөнгийг төгрөгөөр тооцон шилжүүлснээс 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тухайн дүнд 302.6 тэрбум төгрөгийн ханшийн эрсдэл хүлээх тооцоо гарч байна.
5. Чингис бондын 2.5 их наяд төгрөгийн нийт эх үүсвэрээс улсын төсвөөс эргэн төлөгдөх 1,223.9 тэрбум төгрөг, төсөл хэрэгжүүлэгчээс эргэн төлөгдөх 566.6 тэрбум төгрөгийн зээл олгож, 739.5 тэрбум төгрөгийн ашиглаагүй үлдэгдэлтэй байна.
6. Чингис бондын чөлөөт үлдэгдлийг арилжааны 9 банкинд хадгаламж хэлбэрээр байршуулсан бөгөөд банкуудын нийт зээл, үүний дотор чанаргүй зээлийн үлдэгдэл өсч байгаа нь уг хөрөнгийн татан авалтад сөрөг нөлөөлөх эрсдэлтэй байна.
7. Хөгжлийн банкны нийт эх үүсвэр 5.6 их наяд төгрөгт хүрсэн бөгөөд үүнд дүрмийн сангийн хөрөнгө 2.6 хувь, Чингис бонд 44.6 хувь, үлдэх 52.8 хувь нь Засгийн газрын баталгаатай бонд болон зээл байна.
8. Хөгжлийн банкны нийт эх үүсвэрээс 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3.8 их наяд төгрөгийн зээл олгож, үүнээс улсын төсвөөс эргэн төлөгдөх 2.1 их наяд, төсөл хэрэгжүүлэгчээс эргэн төлөгдөх 1.7 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, 1.3 их наяд төгрөг арилжааны банкинд хадгаламж хэлбэрээр байршиж байна.
9. Засгийн газрын тогтоолуудад төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх болон хэрэгжүүлэх байгууллага, олгох мөнгөн дүн, хугацааг шууд заасан, түүнчлэн эрсдэл, үр ашгийг нарийвчлан судалж тодорхойлоогүй төсөл арга хэмжээ байна.

## **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна:

### **Монгол Улсын Ерөнхий сайдад**

1. Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг Улсын Их Хурлын жил бүрийн хаврын чуулганаар батлуулж байх,
2. Чингис бондын хөрөнгөөр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд зээлийн хүү төлөхийг зогсоох, улмаар уг эх үүсвэр болон төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүнд оруулан төлөвлөж, санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх,
3. Чингис бондын хөрөнгийн арилжааны банкинд байршсан чөлөөт үлдэгдлийг эрсдлээс хамгаалах, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд татан авахад бэлэн байдлыг хангах, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
4. Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг сонгохдоо ҮАБЗ-ийн 28/20 дугаар зөвлөмжийн 2.2 дугаар заалт, Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллах,
5. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тавих хяналтыг сайжруулах, үр дүнг нарийвчлан тооцох, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөгдөх зээлийн найдвартай баталгаатай байдлыг хангуулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

## Хөгжлийн банкнаас санхүүжүүлж буй төслийн зээлийн мэдээ

/тэрбум төгрөгөөр/

Төслийн нэр	2012 оны зээлийн үлдэгдэл	2013 оны олгосон зээлийн дүн	2013 онд төлөгдсөн зээлийн дүн	2013.12.31-ний байдлаарх зээлийн үлдэгдэл	2014 оны 12-р сарын 31-ний байдлаар		2014.12.31-ний байдлаарх зээлийн үлдэгдэл
					Олгосон зээл	Төлөгдсөн зээл	
<b>1. Төслийн орлогоос эргэн төлөгдөх</b>	<b>231.9</b>	<b>638.9</b>	<b>141.0</b>	<b>815.3</b>	<b>844.7</b>	<b>37.7</b>	<b>1,688.7</b>
1 Төмрийн хүдрийн үйлдвэрийн төсөл	-	-	-	-	37.7	-	39.0
2 Төрийн орон сууцны корпорацийн төсөл	-	60.0	-	60.0	51.9	-	111.9
3 ХАА, Хөнгөн үйлдвэр	-	270.7	-	270.7	-	31.7	239.0
4 Байшин үйлвэрлэх комбинатын төсөл	-	22.0	-	23.2	19.2	-	45.3
5 Яармагийн орон сууцны хороолол	-	6.7	-	6.7	13.3	1.0	19.0
6 Хөтөлийн цементийн үйлдвэрийн төсөл	85.3	-	-	101.3	-	-	115.5
7 Экспортыг дэмжих, импортыг орлох 888 төсөл	-	-	-	-	255.0	0.5	254.8
8 Арьс шир боловсруулах үйлдвэрлэлийн төсөл	-	-	-	-	60.6	0.0	60.6
9 Багануур ХК	-	18.3	0.5	17.8	0.3	4.5	13.6
10 Геологийн төв лаборатори	-	-	-	-	0.4	0.0	0.3
11 Эрдэнэс Тавантолгой	139.2	139.3	-	330.8	94.3	-	471.4
12 Төмөртэй ордоос Хандгайт өртөө хүртэлх төмөр зам	-	-	-	-	133.7	-	134.4
13 Авто зам	-	-	-	-	170.6	-	170.6
14 Агаарын тээвэр	7.4	121.9	140.5	4.8	7.7	-	13.2
<b>2. Улсын төсвөөс эргэн төлөгдөх</b>	<b>257.8</b>	<b>1028.1</b>	<b>10.7</b>	<b>1368.6</b>	<b>642.4</b>	<b>15.7</b>	<b>2,120.4</b>
15 Цахилгаан станц	2.8	110.6	-	123.2	72.0	-	216.1
16 Төмөр зам	-	272.4	-	295.5	72.7	-	412.5
17 6%-ын орон сууцны зээлийн санхүүжилт	50.0	31.5	1.5	96.6	-	-	110.1
18 ЖДҮ хөгжүүлэх сан	2.1	34.4	0.3	36.2	12.5	7.3	41.4
19 Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх тө	-	-	-	-	0.5	-	0.5
20 Сайншанд АҮЦ	-	3.3	-	3.3	4.6	-	7.9
21 Монголын хөрөнгийн бирж	-	-	-	-	2.7	-	2.8
22 Амгалан дулааны станц	-	-	-	-	47.4	-	47.1
23 Оюутолгой төслийн санхүүжилт	-	-	-	-	0.5	-	0.5
24 Авто зам	202.5	432.2	8.9	669.5	249.7	8.4	956.3
25 Гудамж төсөл	-	47.9	-	47.9	44.2	-	92.6
26 Дэд бүтэц	0.4	95.8	-	96.4	135.6	-	232.5
<b>НИЙТ ДҮН</b>	<b>489.7</b>	<b>1,667.1</b>	<b>151.7</b>	<b>2,184.0</b>	<b>1,487.1</b>	<b>53.5</b>	<b>3,809.1</b>

## Эх үүсвэр бүрээр санхүүжүүлж буй төслийн зээлийн мэдээ

/тэрбум төгрөгөөр/

Төслийн нэр	Чингис банкны эх үүсвэр	Хөгжлийн банкны эх үүсвэр	Бусад болон зорилтот эх үүсвэр	Нийт зээлийн дүн
1 Авто зам	495.2	461.2	170.6	1,126.9
2 Гудамж төсөл	92.6	-	-	92.6
3 Дэд бүтэц	228.6	3.9	-	232.5
4 Орон сууцны санхүүжилт	111.9	129.1	-	241.0
5 Барилгын материал	94.9	115.5	18.9	229.3
6 ХАА, хөнгөн үйлдвэр	239.0	-	-	239.0
7 Төмөр зам	370.0	42.5	134.4	546.9
8 Цахилгаан станц	37.6	178.6	-	216.1
9 Амгалан дулааны станц	-	47.1	-	47.1
10 Уул уурхай	5.6	486.3	-	492.0
11 Экспортыг дэмжих, импортыг орлох 888	102.0	117.7	-	219.7
12 Арьс шир	-	60.6	-	60.6
13 ЖДҮ	-	41.4	-	41.4
14 Бусад	5.4	18.5	-	23.9
<b>Бүлгийн дүн</b>	<b>1,782.8</b>	<b>1,702.3</b>	<b>324.0</b>	<b>3,809.1</b>

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛСЫН  
ХӨГЖЛИЙН БАНК

33178 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Жуулсны гудамж 4/4, Max Tower 2 давхар,  
Утас: 7013 0513, Факс: (976) 7013 0602

2014.12.18 № 2/1290  
танай 2014.12.05 -ны № 1368 -Т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Санал хүргүүлэх тухай

Та бүхэнд энэ өдрийн мэндийн хүргэе.

Танай байгууллагын 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1368 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн "Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн"-д хийсэн аудитын тайлангийн төсөлд Монгол Улсын Хөгжлийн банк нь Төрийн аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1-д заасан хугацаанд саналаа хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт <sup>154</sup>..... хуудастай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Н.МӨНХБАТ





МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 3 сарын 16 өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

"Төрийн аудитын тухай хууль"-ийн 13 дугаар зүйлийн 13.4.5, "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2, "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:


1. "Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн"-д хийсэн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Монгол Улсын Хөгжлийн банкинд тус тус хүрүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохирч байгуулалтын арга хэмжээ авч, үр дүнг 2015 оны 12 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Сангийн сайд, Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын дарга /С.Төмөрхүү/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД